



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 290

Улаанбаатар хот

Төлөөлөгчийн газрыг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон Даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.2.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Практикал даатгал” ХХК-д Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо, Сонсголонгийн гудамж, “Хүлэг” үйлчилгээний төвийн 1 давхарт нэг, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 01 дүгээр хороо, “Бообш” ХХК-ийн байр, 401 тоотод нэг, нийт хоёр төлөөлөгчийн газар нээснийг бүртгэсүгэй.
2. Төлөөлөгчийн газар нээх болсонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 15 хоногийн дотор Хороонд ирүүлэхийг “Практикал даатгал” ХХК /Э.Баярмагнай/-д үүрэг болгосугай.
3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН